

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/331

Номгон

Нийтийг хамарсан ажил арга хэмжээг зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “д”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24.5, 30.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн бүтээн байгуулалт, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, нийтийг хамарсан ажил арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч Г.Энхбаяр (Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого, Уул уурхай хариуцсан орлогч)

Нарийн бичгийн дарга А.Өлзийжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: С.Байгалмаа (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Д.Сарангарав (Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Т.Хишигбаатар (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Б.Молор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Алтангоо - (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн)


2.Орон нутгийн бүтээн байгуулалтын нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд хамрагдсан иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж, ажлын гүйцэтгэл, цагийн бүртгэл, урамшуулал олголтод хяналт тавьж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Д.Амарсанаа), Баянхонгор-Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга (Т.Отгонбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

621010011

2.

3.Нийтийг хамарсан ажил арга хэмжээний явц, үр дүнгийн талаар 14 хоног тутамд аймгийн Засаг даргад, ажлын гүйцэтгэлийн эцсийн үр дүн, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН